

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг

Ханбогд сум

2016 оны 11-р сарын 23

Ханбогд сумын Гурван талт зөвлөл (ГТЗ) Ханбогд сумын ээлжит хурал 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд ГТЗ-ийн гишүүд, Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын чиглүүлэгч нараас гадна, Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг (ОТМШБ) болон Хөндлөнгийн шинжээчдийн багийн (ХШБ) судлаачид, Малчдын төлөөллийн гадаад дотоодын зөвлөхүүд, Оюу толгой компанийн Орон нутгийн хэлтэсийн ажилтнууд оролцсон болно.

Энэ хурлаар Ханбогд сумын малчдын ахуй амьжиргаа, нийгэм соёлын байдалд гарсан сүүлийн арав гаруй жилийн өөрчлөлт, үүнд Оюу толгой компанийн үйл ажиллагааны нөлөөлөл, нөхөн олговрын хөтөлбөр зохистой байсан эсэх талаар хараат бус үнэлгээ хийж дүгнэлт гаргах судалгаа, Ундай голын гольдрол өөрчлөлтийн улмаас үүссэн хам нөлөөллийн 2-р шатны судалгааны урьдчилсан тайланг ОТМШБ, ХШБ-ийн судлаач шинжээч нар танилцуулсан. Зөвлөлийн гишүүд эдгээр судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжийн талаар тодруулах зүйлээ судлаачдаас асууж, орхигдсон болон тодорхойгүй асуудлаар санал дүгнэлтээ хэлж, хурлын дараа өөрсдийн саналаа бичгээр судлаачдад илгээсэн юм. Судалгааны эцсийн тайланг 1-р сард бэлэн болгож ГТЗ-д танилцуулах бөгөөд Зөвлөл уг тайланг ирэх оны 1 дүгээр сард багтааж, сумын малчид, олон нийтэд танилцуулахаар төлөвлөж байна.

Мөн хурлын үеэр, 2011 оны Нөхөн олговрын гэрээний (Гэрээ) хугацаа 2016 оны 11 сард дуусгавар болж байгаатай холбогдуулан уг Гэрээний 10.1-р заалтын дагуу Гэрээний хэрэгжилт болон Төслийн нөлөөллийн талаар үнэлгээ хийсний дараа Гэрээний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр тусгасныг үндэслэл болгон Малчдын төлөөлөл болон орон нутгийн Засаг захиргааны төлөөллийн зүгээс уг Гэрээний асуудлыг Нөхөн олговрын ажлын хэсэг буюу ГТЗ эцэслэн шийдэх хүртэл Гэрээний дагуу Зам арчилгааны ажил эрхэлж буй малчин өрхүүдийн ажил эрхлэлтийг үргэлжлүүлэх хүсэлт гаргасан.

Энэхүү хүсэлтийг ОТ компанийн удирдлага судалж үзээд, Гэрээний асуудлыг ГТЗ эцэслэн шийдэх хүртэл нөхөн олговорт хамрагдаж буй малчдын цаашдын тогтвортой амьжиргааг дэмжихэд чиглэсэн “Амьжиргааг дэмжих сургалтын хөтөлбөр” хэрэгжүүлэхээр талууд тохирсон болно. Энэ хөтөлбөрөөр 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн гишүүд бие даан ажил хөдөлмөр эрхлэх, цаашид өрхийн амьжиргаагаа дэмжих чиглэлээр шаардлагатай ур чадвар олгох сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт 12 сарын хугацаанд хамрагдах болно. Хөтөлбөрийн бэлтгэл ажил хийгдэж эхэлсэн бөгөөд хэрхэн оновчтой зохион байгуулах асуудлаар сургалтыг явуулах Дорнод Политехник Коллеж, нөхөн олговрын өрхүүдтэй ГТЗ хамтран ажиллаж байна. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг Зөвлөлийн мэдээлэлд хамтруулан тухай бүрд олон нийтэд хүргэх болно.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.